



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр


Дугаар 5/341

Улаанбаатар хот

Г И.Замэндийг албан тушаалд томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.3, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, 77.7.9, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ын 2.1, Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөлийн 2022 оны 34 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05/6551 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцэж, нэр дэвшсэн Ичинхоролын Замэндийг 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс арван хоёр сарын туршилтын хугацаагаар Татварын ерөнхий газрын харьяа Дундговь аймгийн татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагчийн албан тушаалд томилсугай.
2. И.Замэндийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, үнэлж дүгнэх, ёс зүй, сахилга хариуцлагын байдалд хяналт тавих, албан тушаалын цалин, нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг Дундговь аймгийн татварын хэлтэс (М.Туяацэцэг)-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т үүрэг болгосугай.

ДАРГА /  Б.ЗАЯАБАЛ

151601796